



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

48090 Дундговь аймаг, Сайнцагаан сум
Утас: 70592439, 70592208, 70593208
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

2020.07.30 № 111

танай _____ -ны № _____ -т

Г ЦАГААНДЭЛГЭР СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНД

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн хурлын 2020 оны сонгуульд оролцох Цагаандэлгэр сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох Цагаандэлгэр сумын Монгол ардын нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” болон холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Цагаандэлгэр сумын Монгол ардын намын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцоо ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Цагаандэлгэр сумын Монгол ардын намын мөрийн хөтөлбөр / З.. хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сумын сонгуулийн хороонд

Хавсралт .З.. хуудастай.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

П.ТӨВСАНАА





ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРӨЛЦОХ ДУНДГОВЬ АЙМГИЙН ЦАГААНДЭЛГЭР СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Мөрийн хөтөлбөр	Зорилт, арга хэмжээ
НЭГ. Амьдрах орчин, дэд бүтэц	<p>1.1 Сумын суурин өрхөд</p> <p>1.1.1 Орчин үеийн стандартад нийцсэн орон сууцны барилгажилтын ажлыг эхлүүлнэ.</p> <p>1.1.2 Нэгдсэн халаалтын шугамыг үе шаттайгаар өргөтгөж хэрэглэгч өрхийн тоог нэмэгдүүлнэ.</p> <p>1.1.3 Цахилгаан эрчим хүчний дэд бүтцийн шинэчлэл хийнэ.</p> <p>1.1.4 Сумын айл өрхийн нүхэн жорлонг “Эко 00” болгоно.</p> <p>1.2 Сумын малчин өрхөд</p> <p>1.2.1 Малчдын дундын сан байгуулж, бэлчээр нөхөн сэргээх, худаг гаргах, хороо бууц барих ажилд зарцуулна.</p> <p>1.2.2 Малын гаралтай түүхий эд авах цэг бий болгоно.</p> <p>1.3 Нийт өрхөд</p> <p>1.3.1 Ахуйн үйлчилгээний барилгыг ашиглалтад оруулж, гар утасны засвар, үсчин, оёдол, гуталчин зэрэг үйлчилгээг тогтмол ажиллуулна.</p> <p>1.3.2 “Сумын хөгжил”-ийн хүрээнд жишиг сум болох ажлыг эхлүүлнэ.</p> <p>1.3.3 Соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулж, техник хэрэгслийг үе шаттай шинэчилнэ.</p> <p>1.3.4 Сумын цэцэрлэгийн барилгыг шинэчлэн барина.</p>
	<p>2.1 Сумын суурин өрхөд</p> <p>2.1.1 Нийтийн халуун усыг төвлөрсөн халаалтад холбож гүний худгаас усыг холбож байнгын ажиллагаатай болгоно.</p> <p>2.1.2 Гэмт хэргийн тоог бууруулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор гэрэлтүүлэг, камержуулалтыг сайжруулж нэмэгдүүлнэ.</p> <p>2.1.3 Сумын хог хаягдлын менежментийг сайжруулна.</p> <p>2.2 Сумын малчин өрхөд</p> <p>2.2.1 Мал нядалгааны цэгийг байнгын ажиллагаатай болгоно.</p> <p>2.2.2 “Монгол мал-2” хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимиийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим,</p>



ХОЁР. Уйлчилгээ, сайжруулалт	<p>хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулна.</p> <p>2.2.3 Монгол малын махыг олон улсад сурталчлан таниулж “Дундговийн Max”, “Дундговийн Айраг” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.</p> <p>2.3 Нийт өрхөд</p> <p>2.3.1 Мэргэжлийн засварчин дэмжиж, авто засварын газрыг тогтмол үйл ажиллагаатай болгоно.</p> <p>2.3.2 Ахмадын байрыг тохижуулж тогтмол үйл ажиллагаатай болгоно.</p> <p>2.3.3 Ясли ажиллуулах эхлэлийг тавина.</p> <p>2.3.4 Боржигон найр, соёл уламжлалаа түгээн дэлгэрүүлэх “Айрагны баяр” зохион байгуулна.</p> <p>2.3.5 Зорилтод бүлгийн өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.</p>
ГУРАВ. Мэдлэг боловсрол	<p>3.1 Сумын суурин өрхөд</p> <p>3.1.1 Төрийн албанад ажиллаж буй албан хаагчдыг ур чадвараа дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулна.</p> <p>3.1.2 Сургууль, цэцэрлэгийн багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаанд хамруулна.</p> <p>3.2 Сумын малчин өрхөд</p> <p>3.2.1 Мал аж ахуйн мэргэжилтэн болон малчдыг мах, сүүний гарц сайжруулах чиглэлээр малын үйлдвэр угсаа сайжруулах туршлага судлуулах, уулзалт зөвлөгөөнд оролцуулна.</p> <p>3.2.2 Малчдын улирлаас хамаарсан орлогын эх үүсвэрийг хэрхэн зохицуулах санхүүгийн боловсрол олгоно.</p>
ДӨРӨВ. Эрүүл мэнд	<p>4.1 Сумын малчин өрхөд</p> <p>4.1.1 Малчин бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.</p> <p>4.2 Нийт өрхөд</p> <p>4.2.1 “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөр хэрэгжүүлнэ.</p> <p>4.2.2 “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг /ангина/ өвчний эрт илрүүлж эмчлэн, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх “Эрүүл ирээдүй” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.</p>



<p>ТАВ. Дэмжлэг, арга хэмжээ</p>	<p>5.1 Сумын суурин өрхөд</p> <p>5.1.1 Орон нутагт шаардлагатай мэргэжлээр нутгийн залуу боловсон хүчнийг бодлогоор дэмжин бэлтгэж хөдөө, орон нутагт ажиллуулна.</p> <p>5.1.2 Суманд шинээр хашаа байшин, сууц барьж буй иргэдийг ипотекийн зээлд хамруулна.</p> <p>5.1.3 Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.</p> <p>5.2 Сумын малчин өрхөд</p> <p>5.2.1 Мал цөөтэй өрх, залуу малчдыг малжуулах ажлыг эрчимжүүлнэ.</p> <p>5.2.2 Хөдөө аж ахуйн салбарт малчдын залгамж халаагааг бэлтгэх "Илгээлтийн эзэн-III" аяныг хэрэгжүүлнэ.</p> <p>5.2.3 Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой байгальд халгүй энгийн механик арга болон микробиологийн аргыг хослуулан тэмцэж бэлчээрийг хамгаална.</p> <p>5.2.4 Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, малын эмч, зоо техникчдийг бодлогоор дэмжин бэлтгэж хөдөө, орон нутагт ажиллуулна.</p> <p>5.2.5 Халдварт өвчинтэй тэмцэх, мал сүргийг бүрэн вакцинжуулах, баг бүрийг мал угаах ванн-тай болгож бог малыг 100 хувь хамруулна.</p>
--------------------------------------	---



Цагаандэлгэр сумын Монгол Ардын намыг төлөөлж

МАН-ын дарга



Д.Мягмардорж

2020.06.24